

**СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР СУМ ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 6 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

Төрийн удирдлагын чиглэлээр:

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг “Хүмүүнлэг багачууд-Монголын ирээдүй” уриан доор зохион байгуулан өнгөрүүллээ.

2022 оны 6 сарын 6-аас 16-ны өдрүүдэд 10 жил тутам нэг удаа явагддаг Хөдөө аж ахуйн тооллогыг зохион байгуулж, нийт 325 өрхийг хамруулан ажилласан.

2022 оны 6 сарын 13-нд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал хуралдаж 2022 оны төсөвт тодотгол хийж, цаг үеийн бусад асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргасан.

2022 оны 6 сарын 19-нд Шинэбулаг баг буюу 15-8-3 хэсэгт сумын Иргэдийн Төлөөлөгчийн хурлын нөхөн дахин сонгууль зохион байгуулагдсан.

Аймгийн Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс, сумын Засаг даргын Тамгын газраас хамтран 5 сумын бүсийн сургалт, зөвлөгөөнийг 6 сарын 20-нд зохион байгуулсан.

Хэнтий аймгийн Улсын тэргүүний Баян Овоо сумын үйл ажиллагаатай “Туршлага солилцох уулзалт”-нд сум, байгууллага, багийн дарга нар, ЗДТГ-ын мэргэжилтнүүд хамрагдсан.

6 сарын 20-оос 23-ны өдрүүдэд тээврийн хэрэгслийн үзлэг, оношлогоо зохион байгуулагдлаа.

3, 5 дугаар багууд багийн Иргэдийн нийтийн хурлаа зохион байгуулж цаг үеийн асуудлаа хэлэлцсэн.

Засгийн газрын мөрийн хөтөлбөр, сайд, аймгийн засаг дарга нарын Ерөнхий сайдтай байгуулсан гэрээнд Газар нутгийн нэршилд тодотгол хийх, нэршил тогтоох заалтын хүрээнд Аймгийн Засаг дарга "Инженер Геодези" ХХК- тай Газар нутгийн нэршилд тодотгол хийх, нэршил тогтоох гэрээ байгуулж уг гэрээний хүрээнд тус компани орон нутагт ажиллалаа.

САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын 2022.04.20-ны А/183 тоот захирамж гарч сумын хэмжээнд эд хөрөнгийн тооллогын ажил явагдаж дууссан.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022.06.13-ны өдрийн А/11 тоот тогтоолоор 2022 оны төсөвт тодотгол оруулж төсвийн хуваарийг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст тушаасан.

Байгаль орчин , Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Сумын нэгдсэн хогийн тэлсэн хог хаягдлыг хогийн канав татсан нүхрүү түрж хог хаягдал хаях боломжийг хангаж ажиллалаа.

Аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран тус сумын 1-р багийн нутагт 20 ширхэг монгол тарвага нутагшуулах ажлыг зохион байгуулсан.

Нөхөн сэргээлт хийсэн нэгдсэн хуучин хогийн цэгт 1000 ширхэг хайлаас модыг тарьж услах, хашаажуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

3-р багийн нутаг Арын нуурын геологи толгойд хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа Моль метиал ХХК-ын хайгуулын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийсэн

Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Орон нутгийн хөгжлийн сангийн 14.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар /арван дөрвөн сая таван зуун мянган төгрөг/ төв засмал зам дагуу 1 м газар болон хуучин нөхөн сэргээлт хийсэн хогийн цэг, бурхант хөшөө төсөвт байгууллагын гадна талбай гэсэн зэрэг газруудад 5-н төрлийн 5830 мод тарьж, услаж байна.

6 сарын 16 өдөр Дорнод монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал төсөлтэй хамтран мах, сүүний чиглэлийн 50 хээлтэгч үхэрт зохиомол хээлтүүлэг хийсэн.

Билүүт өсөх хоршоотой хамтран ажиллах гэрээний дагуу мал үржлийн ажил үйлчилгээг суманд тасралтгүй явуулах зорилтын хүрээнд Дорнод монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал төслөөс нийт 30 сая төгрөгний хашаа, бусад багаж хэрэгслээр хангаж, хамтран ажиллах гэрээ байгуулсан.

Хаврын тариалалтаар сумын хэмжээнд 1 ААН, 1 байгууллага, 8 иргэн тариалалт хийснээс улаан буудай 320 га, рапс 250 га, овъёос 279 га, ногоон тэжээл 52 га, төмс 10 га, хүнсний ногоо 3.4 га тус тус тариалсан

4*6 хэмжээтэй 2ш, 12*6 хэмжээтэй 1ш зуны хүлэмжний аж ахуйг шинээр 3 иргэн барьж байгуулан нарийн ногоо тариалалт эхлүүлээ

Бэлчээр хаших ажлыг турших зорилгоор анх удаагаа 3-р багт эхлүүлсэн бөгөөд нийт 1 га бэлчээрийг хашиж, өнжөөх ажлыг Дорнод монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал төслөөр хийж гүйцэтгээд байна

Эрүүл мэнд, Боловсролын чиглэлээр:

Ахлах, бэлтгэл бүлгийн эцэг эхийн дунд “Спортын өдөрлөг” зохион байгуулах. “Илүүдэл жингүй эртэч монгол” аяны хүрээнд цэцэрлэгийн ахлах бэлтгэл бүлгийн эцэг эх хүүхдүүдийн дунд “Спортын өдөрлөг” хөгжөөнт буухиа тэмцээнийг зохион явуулсан. Тус тэмцээнд нийт 4 бүлгийн 12 хүүхэд, 12 эцэг эхийн хамт удирдамжийн дагуу 4 төрлийн хөгжөөнт буухиа тэмцээнд амжилттай оролцсон.

Эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх, багш, эцэг эх, хүүхэд гэсэн гурвалсан харилцааг идэвхжүүлэх, хүүхэд ээж ааваараа бахархах, өөртөө итгэх итгэл төрүүлэх зорилгоор 6-н бүлгийн дунд “Аав, ээж, би” танин мэдэхүйн тэмцээнийг 5 төрлөөр амжилттай зохион байгуулсан.

Улсын тэргүүний цэцэрлэгт суралцдаг авъяаслаг хүүхэд багачуудын 2021-2022 оны хичээлийн жилд сурч мэдсэнээ тайлагнах “Балчир насны андууд” тайлан тоглолтыг сумын соёлын төвд амжилттай зохион байгууллаа.

Соёл урлагийн чиглэлээр:

НЭГ: ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

Зүүн бүсийн жишиг соёлын төв нь орчин үеийн техник хэрэгсэлээр бүрэн хангагдсан бөгөөд "Баян Хундар" уулын тахилгад зориулсан баяр наадмын нээлтийн үйл ажиллагааны урлаг соёлын арга хэмжээг зохион байгуулж, хөгжим техникээр үйлчилж, соёл урлагийн үйлчилгээг 200 хүнд хүргэж ажилласан.

Монгол Улсын Соёлын Яамны санаачилгаар зохион байгуулсан "Соёлын салбарын шинэ сэргэлтийн бодлого" хэлэлцүүлэг, сургалтанд соёлын төвийн дарга Л.Батжаргал хамрагдаж, "САЙН ТУРШЛАГА-ЗҮҮН БҮСИЙН ЖИШИГ СОЁЛЫН ТӨВ" илтгэл тавьж оролцсон.

ERP, E-Mongolia, тоон гарын үсэг зэрэг цахим хэрэгсэлүүдийг албан хэрэгцээндээ нэвтрүүлсэн. Байгууллагын бичиг хэргийн ажлыг соёлын өвийн ажилтан Д.Болорцэцэг хавсран гүйцэтгэж байна.

Сүхбаатар сумын газар нутагт байрлах “Баянхундар”, “Дэлгэр овоо”, “Пунгийн сүмийн Алтан овоо” зэрэг уул овоодын мэдээллийг аймгийн Эрдэнэмандал хийдийн тэргүүн лам Н.Цамбанүрдэвээс тодруулж, мэдээллийн сан хөмрөгт баяжилт хийсэн.

Зуны зугаатай амралтыг угтан хүүхэд багачуудын чөлөөт цагт зориулсан "ДУГУЙТАЙ АЯЛАЛ"-ыг амжилттай зохион байгуулсан. Дугуйтай аялалд ЕБС-ийн сурагчид хамрагдаж, түүх соёлын үл хөдлөх дурсгал болох “Нийгэм хонгор”-ын хөшөө, “Бурхантай хөшөө”, “Дашгүндэдлэн хийдийн туурь”, “Дарханхааны хүлгүүд” цогцолбор зэргээр аялаж, хөгжөөнт "Буухиа", танин мэдэхүйн "АХА" тэмцээн, "Дугуйн уралдаан"-уудыг зохион байгуулж, шагналт 3-н байрыг шалгаруулж, нэгэн өдрийг бүтээлчээр өнгөрүүлсэн. Нийт 9 хүүхэд хамрагдсан.

Сүхбаатар сумын Д.Сүхбаатарын талбайн их засварын нээлтэнд зориулж “Задгай шоу” зохион байгуулсан. Шоу арга хэмжээг амьд хөгжмийн хамтлагийн 5 уран бүтээлч, Жаахан шарга театрын 2 дуучныг оролцуулсан бөгөөд нийтдээ 170 хүнд хүрсэн.

Оюуны өмчийн зөвшөөрөлтэйгөөр, хамтран ажиллах гэрээ хийж, Т Энтертайнмэнтийн 2022 оны шинэ бүтээл "СОЛИЛЦОО" уран сайхны киног 2022.06.21 өдөр олон нийтэд толилуулж танхимаар 22 хүнд хүргэсэн.

ХОЁР: НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Номын сангийн фондын тооллого хийж номыг үсэг дараалал ангилалд оруулсан.

Бясалгалын багш Шри Чойман бүтээлийн үзэсгэлэн соёлын төвд дэглэн тавигдсан. Энэхүү үзэсгэлэнг хүүхэд залууст үзүүлж сонирхуулах тал дээр дэмжин ажилласан бөгөөд номын санд 8 ширхэг номоор баяжилт хийсэн.

6-р сард нийт үйлчилгээ-4 ном олгох үйлчилгээ- 16, байнгын уншигч-2, ирэгсэд-33, цахим уншигчид-46 , цахимд хөврүүлсэн ном- 230, хандиваар 12 ширхэг 100,000 төгрөгний номоор баяжилт хийгдсэн.

Сүхбаатар аймгийн Эрдэнэмандал хийдийн Тэргүүн Н.Цамбанүрдэв “Эрдэнэ хийдийн түүх”, “Сүхбаатар аймгийн зарим сүм хийд, лам нарын баримтууд” - 4ш, Соёлын мэргэжилтэн Б.Золхүү “Уламжлал”, “Үнэт өв-үгэн эрдэнэ”-4ш номыг хандиваар, худалдаагаар-110,000 төгрөгний үнэ бүхий “Талын түрлэг”, “Сономбалжирын Буяаннэмэх, “Саруул талын найрагчид” нийт 12 ширхэг номоор баяжилт хийгдсэн.

ГУРАВ: СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:

2022 оны хагас жилд ЕБС-ийн 198 хүүхдэд музейн үйлчилгээг үнэ төлбөргүй хүргэсэн.

Сүхбаатар сумын газар нутагт байрлах “Баянхундар”, “Дэлгэр овоо”, “Пунгийн сүмийн Алтан овоо” зэрэг уул овоодын мэдээллийг аймгийн Эрдэнэмандал хийдийн тэргүүн лам Н.Цамбанүрдэвээс тодруулж, мэдээллийн сан хөмрөгт баяжилт хийсэн.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Зүүн бүсийн жишиг соёлын төв нь 2022 оны хагас жилийн байдлаар 80 үйл ажиллагаа зохион байгуулж, танхимын болон явуулын үйлчилгээгээр 5506 үзэгчид, цахимаар 8500 үзэгчид нийтдээ 14.006 үзэгчдэд соёл урлагийн үйлчилгээ, арга хэмжээг хүргэн ажилласан байна. Хамрагсадын тоо 2109

МЭДЭЭ ГАРГАСАН :

Хууль, эрх зүйн мэргэжилтнийг түр орлон гүйцэтгэгч:

Э.Дэлхийцэцэг

ХЯНАСАН:

Засаг даргын Тамгын газрын дарга

/Ц.Сүхболд/